115

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.08.20 № 12

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

Газрын тос боловсруулах
үйлдвэрийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн ажлын гүйцэтгэлийн явцын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
2. Тус төслийн хүрээнд Улсын төсөв болон Монгол Улсын хөгжлийн банкнаас санхүүжилт олгож эхэлсэн болон зогссон хугацаа, олгосон санхүүжилтийн нийт дүн, түүний зарцуулалтын талаарх мэдээлэл;
3. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас авсан зээл, үүнтэй холбоотойгоор байгуулсан гэрээнүүд, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтүүд болон зээлийн хөрөнгийн зарцуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
4. Төслийн 1, 2, 3, 4 багц ажлын хүрээнд хийгдсэн дэд бүтцийн төслүүд тэдгээрийн үр дүнгийн талаар;
5. Төслийн хүрээнд ерөнхий, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгч гадаад болон дотоодын компаниуд тус бүрийн хариуцсан ажлын үнийн дүн, ажлын гүйцэтгэлийн явцын болон хийсэн ажлын тайлан, тэдгээрийн сонгон шалгаруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
6. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн үйл ажиллагааны зардлын дэлгэрэнгүй мэдээлэл;
7. Монгол Улс 2020-2024 онд шатахуунд зарцуулж буй мөнгөн дүн болон газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол;
8. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн үйл ажиллагаа болон санхүүд хийсэн дотоодын болон олон улсын хөндлөнгийн аудитын байгууллагын тайлан, дүгнэлтүүд;
9. Бүтээгдэхүүн хуваах гэрээний талаар;
10. Төслийн хүрээнд бий болох ажлын байрны тоо, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д одоо ажиллаж буй нийт ажилтнуудын тоо, үүнээс газрын тосны үйлдвэрийн хотхонд орон сууцанд хамрагдан амьдарч буй ажилтнуудын тоон мэдээлэл;

20240816

11. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нь газрын тос хайх болон ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшдэг эсэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл зэрэг болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлж, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Л.МӨНХБАЯСГАЛАН

20240016